



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/48

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны “ Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинчлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- |                           |  |
|---------------------------|--|
| Үнэлгээний хорооны дарга: | Ч.Сугармаа<br>(Засаг даргын орлогч дарга)  |
| Гишүүд:                   | Б.Даваадолгор<br>(3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)<br>О.Отгонбаяр<br>(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)<br>Б.Базаррагчаа<br>(Иргэний төлөөлөл) |
| Нарийн бичгийн дарга:     | Б.Алтансүх<br>(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)   |

2. “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинчлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Ч.Сугармаа )-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ